



**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН
56 ДУГААР ЗҮЙЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛЫГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн тесел боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр үйлдсэн Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод Монгол Улс 1989 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орсон.

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 123-т Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2021 онд батлахаар тусгасан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт "Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана" гэж заасны дагуу Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах шаардлагатай.

1.2. Практик шаардлага

Канад Улсын Монреаль хотноо 2016 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсан Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын 39 дэх Ассамблейн чуулганаар Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр үйлдсэн Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд протокол байгуулах замаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтсон.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд: "Агаарын навигацийн комисс Хэлэлцэн тохирогч улсуудаас нэр дэвшүүлсэн хүмүүсийн дотроос Зөвлөл томилсон 19 гишүүнээс бүрдэнэ. Эдгээр хүмүүс нь агаарын тээврийн салбарын шинжлэх ухаан, практик ажлын зохих туршлага, мэргэшилтэй байна. Зөвлөл хэлэлцэн тохиролцогч улсуудад нэр дэвшүүлэх хүсэлт тавина. Агаарын навигацийн комиссын даргыг Зөвлөл томилно." гэж заасан багеөд дээрх протоколоор Агаарын навигацийн комиссын гишүүдийн тоо 19 (арван ес) байгааг 21 (хорин нэг) болгон нэмэгдүүлэхээр тогтсон.

Монгол Улс ОУИНБ-ын бүрэн эрхт гишүүн болсноос хойш тус байгууллагаас баталсан бодлого, стандарт болон санал болгосон зөвлөмжийг хүлээн авч

хэрэгжүүлэх, үл тохиролыг мэдээлэх, аюулгүй ажиллагааны өргөтгесэн аудитад хамрагдах, жил бүрийн гишүүнчлэлийн хураамж төлөх зэргээр "оролцогч" улсын байр суурийг хадгалж ирсэн.

Дэлхийн агаарын тээврийн тэргүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дунд байрлалтай Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Ази, Европ тивийг холбосон хамгийн дет агаарын зам дамжин өнгөрч байна.

Монгол Улс нь Ази, Номхон далайн бус нутгийн ОУИНБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор бус нутгийн агаарын навигацийн гол түшиц орон зай болох, олон улсын нисэх буудлын ашиглалтыг сайжруулах, агаарын тээвэр өргөжин хөгжихэд ач холбогдолтой юм.

Хоёр. Хуулийн төслийн өрөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулсан Протоколыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улс нь ОУИНБ-ын үйл ажиллагаанд оролцоогоо идэвхжүүлэхэд түлхэц болж, Агаарын навигацийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх санаачилгад өөрийн хувь нэмрийг оруулж, цаашид бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд буюу мэргэжлийн ажилтнуудыг Агаарын навигацийн комисст ажиллуулахад дэмжлэг болох юм.

Протоколыг соёрхон батлах нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалтай тус тус нийцнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа серег үр дагавар гарахгүй, улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай нийцсэн бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.